

Хорин нэгдүгээр зүйл

Албан бичиг баримтын нотлох

чалвар

Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн албан бичиг баримт Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэрт тэдний албан бичиг баримтын адил нотлох чадвартай байна.

Иргэний гэр бүлийн байдлын тухай бичиг баримтыг солилцох

Хорин хоёрдугаар зүйл

1. Хэлэлцэн Тохирогч нэг Этгээд Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн иргэний гэр бүлийн байдлын бүртгэлээс төрөх, гэрлэх, нас барахтай холбогдсон зүйлийг Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдэд илгээнэ.

2. Энэ зүйлийн I дэх ангид заасан зүйлийг Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн дипломат төлөөлөгчийн буюу консулын газарт унэ төлбөргүйгээр жил бүр илгээя байна.

3. Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд аль нэгнийхээ хусэлтээр албан хэрэгизэнд зориулж иргэний гэр бүлийн байдлын тухай гэрчилгээг бие биедээ илгээж байна.

4* Энэ зүйлийн 3 дахь ангид заасан даалгаврыг илгээх буюу биелүүлэхдээ Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд Гэрээний 9-р зүйлд заасан журмаар харилпана.

Хорин гуравдугаар зүйл

I. Хэлэлцэн Тохирогч хоёр Этгээд Хэлэлцэн Тохирогч нэг Этгээдийн иргэний гэр бүлийн байдлын талаар хучин төгөлдөр болсон шуухийн шийдвэрийг Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээддээ харилцан илгээнэ.